



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар A/56

Халбан

**Газар ашиглуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.12 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.11 дэх заалт, 27.1.14 дахь заалт, АМГ-ын 2012 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн МУ-017098 дугаартай тусгай зөвшөөрөл, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар ашиглах хүсэлт ирүүлсэн “Хургатай хайрхан” ХХК (РД5104424)–д Цэцэрлэг сумын Ренчинжугнай багийн Овоот нэртэй газар орших МУ-017098 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дээр байршилтай 5 га газрыг уурхайн кемпийн зориулалтаар, 50 га газрыг нүүрс угаах үйлдвэрийн зориулалтаар тус бүр 5 жилийн хугацаатай ашиглуулсугай.

2. Газар ашиглуулахтай холбоотой баримт бичгийг зохих журмын дагуу бүрдүүлж, газар ашиглах гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрыг Улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Н.Цасанчихэр)-т даалгасугай.

3. Газрыг гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу ашиглахыг газар ашиглагч хуулийн этгээд “Хургатай хайрхан” ХХК-ны ерөнхий захирал (Д.Ачит-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

